

# Цагаантолгой ХК-ийн хувьцаа ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022/4/29

№ 1

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

**Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон  
санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг  
батлах тухай :**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2022 оны 04-р сарын 29 –ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хавсралт 1-д заасны дагуу баталсугай.
2. ТУЗ-аас гаргасан дүгнэлтэд анхаарал тавьж ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

Хурлын дарга Т.Ууганбаяр



# Цагаантолгой ХК-ийн хувьцаа ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

---

2022/4/29

№ 2

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

**Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг**

**батлах тухай :**

1. Цагаантолгой ХК -ийн компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг баталсугай.
2. Уг төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

Хурлын дарга Т.Ууганбаяр



# Цагаантолгой ХК-ийн хувьцаа ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022/4/29

№ 3

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болон**

**хараат бус гишүүдийг батлах тухай :**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах хэсэг, Цагаантолгой ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 4 сарын 29-ны өдрийн хурлын тэмдэглэл болон тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь :

Цагаантолгой ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр :

1. Эрдэнэбаяр овогтой Янжинлхам
2. Амгалан овогтой Чимгээ
3. Эрдэнэ-Очир овогтой Эрдэнэбаяр
4. Эрдэнэбаяр овогтой Зандан
5. Пүрэвдорж овогтой Пүрэвсүрэн
6. Төмөрбаатар овогтой Халиун

Цагаантолгой ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр :

- 1.Түмэнбаатар овогтой Сарангэрэл
- 2.Ганболд овогтой Энхцэцэг
- 3 .Алтанхуяг овогтой Орги нарыг тус тус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр сонгогдсониыг баталсугай.

Хурлын дарга Т.Ууганбаяр



# Цагаантолгой ХК-ийн хувьцаа ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022/4/29

№ 4

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

## ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14, 62.1.1 дахь заалт, 2022 оны 4 сарын 29 ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Цагаантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

Хурлын дарга Т.Ууганбаяр





# Компаний 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлт

Цагаантолгой ХК-ийн Хувьцаа Эзэмшигчидийн  
Хурлын 2022 оны 4 дугаар сарын 29-ны өдрийн 1 тоот тогтоолын Хавсралт 1

Цагаантолгой ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэнг тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна

2021 оны хувьд дэлхийг хамарсан цар тахлын нөлөөгөөр улс орны эдийн засаг хүндрэл үргэлжилсэн, ДНБ-ий өсөлт ердө 1.4 хувиар өссөн, эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа хумигдаж, гадаадын хөрөнгө оруулалт өмнөх жилүүдтэй харьцуулахад огцом буурч, хөрөнгө оруулагчдын итгэл суларсан хүндхэн жил байлаа. Дотоод, гадаад хүчин зүйлсээс улбаалсан эдийн засгийн хүндрэлтэй байдалд өмнө тавьсан зорилт төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тодорхой сорилтууд гарсантай холбогдуулж цаашид компанид хөрөнгө оруулалт татах, төслийн санхүүжилтийн бусад хувилбаруудийг судлах шаардлагатай. 2021 оны санхүүгийн жилд Монгол улс болон гадаадын улсууд дотоодын хөдөлгөөнийг хязгаарлаж хорио цээрийн дэглэм тогтоосон. Тухайн жилийн хөндлөнгийн аудитийн дүгнэлтэд компаний бодлого өр төлбөр барагдуулах хугацаа болоход хангалттай бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байх шаардалагатай гэж үзсэн ба компани нь хүлээгдэж буй шаардлагыг биелүүлэхийн тулд тогтмол бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байх явдал гэж дүгнэснийг анхааралтай авах хэрэгтэй. Иймд тухайн жилийн мөнгөн урсгалын хэрэгцээ шаардлагыг үнэлсэний үндсэн дээр удирдлагын баг нь өр төлбөр ба эздийн өмчийн харьцааг зохистой байлгахад анхаарал тавин ажиллах нь чухал. ТУЗ-ын зүгээс тус компанийн гүйцэтгэх удирдлага дэлхийн болон Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүнд буюу давагдашгүй хүчин зүйлээс хамааран хангалттай үр дүнд хүрч чадаагүй гэж үзээд, цаашид улам хүчин чармайлт гаргаж сайн ажиллах шаардлагатай гэж дүгнэж байна.

ТУЗ-ийн дарга Э.Янжинлхам

